

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2007.11.29

Дугаар 164

Улаанбаатар хот

ХЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлсний
хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийн 5.3-т заасныг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг 1 дүгээр хавсралтаар, хөлсний хэмжээг тооцох аргачлалыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Хорооны 2006 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 33 дугаар тогтоолын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний төрөл, хөлсний хэмжээг тогтоосон 4 дүгээр хавсралт болон 2006 оны “Аргачлал батлах тухай” 37 дугаар тогтоолын хавсралтын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тооцоолох аргачлалын 4 дүгээр хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, нийтэд сурталчлан ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

Санхүүгийн зохицуулах хорооны
2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн
164 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

	ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ	ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС	
		ЖИЛ БҮР /Хувиар/	НЭГ УДААГИЙН /Төгрөгөөр/
1.	Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс жил бүр төлөх хөлс	3 дугаар сарын 1-ний өдрийн дотор төлөх (тогтоосон хугацаанд зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутам 0.5 хувийн алданги тооцох) 0.05 хувь (доод хязгаар нь 20,000 төгрөг, дээд хязгаар нь 2,000,000 төгрөг байна)	
2.	Оноосон нэр өөрчлөх (СЗХ-ны зүгээс тавьсан шаардлагын дагуу оноосон нэрийг өөрчлөхөөс бусад тохиолдолд)		2,000,000
3.	Хуулинд заасан бусад эрх, зөвшөөрөл олгох		Хорооны тогтоолоор тухай бүрд шийдвэрлэх
4.	Үрэгдүүлж, гэмтээсэн гэрчилгээг нөхөн олгох		200,000
5.	Хуулинд заасан бусад үйлчилгээ үзүүлэх		Хорооны тогтоолоор тухай бүр шийдвэрлэх
6.	Дүрэм болон бусад өөрийн мэдээллийг Хорооны архиваас хуулбарлан нөхөн авах болон бусад үйлчилгээ үзүүлэхэд төлөх хөлс		1,000 (нэг нүүр хуудас)
7.	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах		10,000
8.	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх		100,000

/Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 109 дүгээр тогтоолоор нэмсэн/

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын үйлчилгээний хөлсийг жил бүр төвлөрүүлэх болон тухай бүр нэг удаа төвлөрүүлэх гэж 2 ангилна.

1. Жил бүр төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсийг дараах байдлаар тооцно:

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршооны зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тухайн хоршооны татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнгээс 0,05 хувиар тооцно. Энэхүү зохицуулалтын үйлчилгээний хөлсний доод хязгаарыг 20 000 төгрөг, дээд хязгаарыг 2 000 000 төгрөг байхаар журмын 1 дүгээр хавсралтаар тогтоож өгсөн.

Жишээ 1: “А” хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршоо нь нийт 9 000 000 төгрөгийн татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй гэвэл тооцооллын дагуу 4 500 төгрөгийг төлөхөөр байгаа хэдий ч зохицуулалтын үйлчилгээний хөлсний доод хэмжээ болох 20 000 төгрөгийг төлнө.

Жишээ 2: “Б” хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршоо нь нийт 9 900 000 000 төгрөгийн татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй гэвэл тооцооллын дагуу 4 950 000 төгрөгийг төлөхөөр байгаа хэдий ч зохицуулалтын үйлчилгээний хөлсний дээд хэмжээ болох 2 000 000 төгрөгийг төлнө.

Жишээ 3: “В” хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршоо нь нийт 3 700 000 000 төгрөгийн татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй гэвэл тооцооллын дагуу 1 850 000 төгрөгийг төлнө.

2. Тухай бүр нэг удаа төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараах байдлаар төвлөрүүлнэ.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь оноосон нэрээ өөрчлөх, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд солих, нөхөн олгоход болон хуулинд заасан бусад үйлчилгээ үзүүлэх гэсэн нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаанаас авах хөлсийг журмын 1 дүгээр хавсралтын 2, 3, 4, 5, 6 -д тогтоож өгсөн.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны оноосон нэрийг Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс тавьсан шаардлагын улмаас өөрчилж байгаа бол 1 дүгээр хавсралтад дурдсан хөлс болох 2 000 000 төгрөгийг төвлөрүүлэхгүй.